

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн  
аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/48/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/48/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн  
аудит

**АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн  
аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН  
18 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
С.ЛАГЫЛ ТАНАА

2024.02.06 № 38  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй байна.

**Аудитын гол асуудал**

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

18-р цэцэрлэг Дүгнэлт-1.30

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>26160746.00</u></b>	<b><u>118784193.62</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
31211	Төрийн сангийн харилцах	1729706.00	92414643.62
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b><u>24431040.00</u></b>	<b><u>26369550.00</u></b>
35420	Аж ахуйн материал	10875700.00	10671700.00
35460	Хүнсний материал	1768240.00	390750.00
35470	Бусад хангамжийн материал	11787100.00	15307100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>469079463.60</u></b>	<b><u>463950209.91</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	469079463.60	463950209.91
391	Газар	0.00	0.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	451335463.60	445020177.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	474648000.00	474648000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-55954632.72	-63965265.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31098500.00	43684500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10266333.69	-16956267.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34681942.75	34931842.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23373612.74	-27698832.14
39214	Бусад үндсэн хөрөнгө	1604000.00	1604000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1102400.00	-1227800.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>17744000.00</u></b>	<b><u>18930032.48</u></b>
39301	Програм хангамж	660000.00	2083239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-660000.00	-897206.52
39303	Бусад биет бус хөрөнгө	17744000.00	17744000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>495240209.60</u></b>	<b><u>582734403.53</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1183988.00</u></b>	<b><u>1036724.00</u></b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	917424.00	233024.00
41361	Байгууллагад төлөх өглөг	130300.00	803700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>494056221.60</u></b>	<b><u>581697679.53</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	494056221.60	581697679.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17744000.00	17744000.00
51101	Өмч: - төрийн	17744000.00	17744000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>476312221.60</u></b>	<b><u>563953679.53</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	476312221.60	476312221.60
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	87641457.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>495240209.60</u></b>	<b><u>582734403.53</u></b>

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>318,653,557.75</b>	<b>594,022,809.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,315,857.75</b>	<b>19,195,709.00</b>
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,636,570.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,315,857.75	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	14,259,139.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	300,000.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>265,087,800.00</b>	<b>559,379,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265,087,800.00	559,379,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>103,500.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>35,146,400.00</b>	<b>15,447,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,146,400.00	15,447,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>315,627,292.08</b>	<b>506,381,351.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>315,627,292.08</b>	<b>506,381,351.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>315,421,792.08</b>	<b>501,744,781.07</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>219,654,412.00</b>	<b>355,674,970.26</b>
210101	Үндсэн цалин	184,413,235.00	283,324,398.32
210102	Нэмэгдэл	30,509,107.00	55,254,128.94
210104	Урамшуулал	4,732,070.00	17,096,443.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,708,641.00</b>	<b>42,332,828.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,888,141.00	26,110,935.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,205,200.00	4,068,597.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,764,200.00	3,250,438.02
210204	Ажилгүйдлийн даатгал	441,000.00	812,559.49
210205	Эрүүл мэндийн даатгал	4,410,100.00	8,090,298.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,450,400.00</b>	<b>14,263,500.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,197,900.00	4,153,500.00
210302	Түлш, халаалт	7,452,500.00	9,490,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	620,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,605,200.00</b>	<b>2,324,850.00</b>
210401	Бичиг хэрэг	1,556,750.00	1,865,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	159,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,048,450.00	300,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,002,650.00</b>	<b>58,242,990.00</b>
210502	Хоол, хүнс	34,002,650.00	58,242,990.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>116,200.00</b>	<b>948,100.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	116,200.00	948,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,384,289.08</b>	<b>27,457,542.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,072,800.00	7,668,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	783,000.00	400,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,528,489.08	19,388,392.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>205,500.00</b>	<b>4,636,570.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	205,500.00	4,636,570.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,026,265.67</b>	<b>87,641,457.93</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,026,265.67</b>	<b>87,641,457.93</b>

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>300337700.00</b>	<b>579463670.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>4636570.00</b>
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4636570.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>300337700.00</b>	<b>574827100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>265087800.00</b>	<b>559379200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265087800.00	559379200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>103500.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>35146400.00</b>	<b>15447900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35146400.00	15447900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>298607994.00</b>	<b>488778732.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>298607994.00</b>	<b>488778732.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>298402494.00</b>	<b>484142162.38</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>217719394.00</b>	<b>343672162.38</b>
210101	Үндсэн цалин	178661348.00	232244733.49
210102	Нэмэгдэл	34340422.00	94330985.89
210104	Урамшуулал	4717624.00	17096443.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29462400.00</b>	<b>54471900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20249500.00	37333800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2303400.00	4284500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1842600.00	3427600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460800.00	856800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4606100.00	8569200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9097900.00</b>	<b>14947900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2197900.00	3923500.00
210302	Түлш, халаалт	6100000.00	10224400.00
210303	Цэвэр, бохир ус	800000.00	800000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>103500.00</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	103500.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33830400.00</b>	<b>56865500.00</b>
210502	Хоол, хүнс	33830400.00	56865500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500000.00</b>	<b>500000.00</b>
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>444000.00</b>	<b>882300.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	444000.00	882300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7244900.00</b>	<b>12802400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5524900.00	10155400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1720000.00	2647000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>205500.00</b>	<b>4636570.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	205500.00	4636570.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1729706.00</b>	<b>90684937.62</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1729706.00</b>	<b>90684937.62</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1729706.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>92414643.62</b>

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>17,744,000.00</b>	<b>0.00</b>	<b>473,703,755.93</b>	<b>0.00</b>	<b>491,447,755.93</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			2,608,465.67		2,608,465.67
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>17,744,000.00</b>	<b>0.00</b>	<b>476,312,221.60</b>	<b>0.00</b>	<b>494,056,221.60</b>
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>17,744,000.00</b>	<b>0.00</b>	<b>476,312,221.60</b>	<b>0.00</b>	<b>494,056,221.60</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>17,744,000.00</b>	<b>0.00</b>	<b>476,312,221.60</b>	<b>0.00</b>	<b>494,056,221.60</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			87,641,457.93		87,641,457.93
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>17,744,000.00</b>	<b>0.00</b>	<b>563,953,679.53</b>	<b>0.00</b>	<b>581,697,679.53</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>576556800.00</b>	<b>484142162.38</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>576556800.00</b>	<b>484142162.38</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>576556800.00</b>	<b>484142162.38</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>433845000.00</b>	<b>343672162.38</b>
210101	Үндсэн цалин	275782600.00	232244733.49
210102	Нэмэгдэл	142745600.00	94330985.89
210104	Урамшуулал	15316800.00	17096443.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>55145800.00</b>	<b>54471900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	37792100.00	37333800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4338400.00	4284500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3470700.00	3427600.00

**Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит**

210204	Ажилгүйдлийн даатгал	867600.00	856800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8677000.00	8569200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14947900.00</b>	<b>14947900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3923500.00	3923500.00
210302	Түлш, халаалт	10224400.00	10224400.00
210303	Цэвэр, бохир ус	800000.00	800000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>58419900.00</b>	<b>56865500.00</b>
210502	Хоол, хүнс	58419900.00	56865500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500000.00</b>	<b>500000.00</b>
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>882300.00</b>	<b>882300.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	882300.00	882300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12815900.00</b>	<b>12802400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10168900.00	10155400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2647000.00	2647000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>574827100.00</b>	<b>574827100.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>559379200.00</b>	<b>559379200.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	559379200.00	559379200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>15447900.00</b>	<b>15447900.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	15447900.00	15447900.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1729706.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>92414643.62</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Цэцэрлэг нь “Боловсон хүчнийхээ бүтээмжийг дээшлүүлэх замаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээгээр тэргүүний цэцэрлэг болохыг эрмэлзэх”, “Тохилог орчин чанартай сургалт” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

## Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийсэн байна.

Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87.5 сая төгрөгөөр буюу 117.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1729.7	92414.6	90684.9
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	24431.0	26369.5	1938.5
Үндсэн хөрөнгө	469079.5	463950.2	-5129.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>495240.2</b>	<b>582734.4</b>	<b>87494.2</b>
Өр төлбөр	1184.0	1036.7	-147.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	494056.2	581697.7	87641.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>495240.2</b>	<b>582734.4</b>	<b>87494.2</b>

## Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгө оны эцэст 92.4 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 90.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 90.9 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс, 1.5 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлаас үлдсэн мөнгө байна.

Бараа материал данс оны эцэст 26.4 сая төгрөг болж оны эхнээс 2.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: хүнсний материал 0.4 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 15.3 сая төгрөгийн, аж ахуйн материал 10.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 463.9 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 14.2 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 19.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эцэст 1.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь түлш халаалт, бусад тооцооны өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 582.7 сая төгрөг болж 87.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 87.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 248.3 сая, орон нутгийн төсвөөс 15.4 сая, нийт зарлагыг 263.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 449.7 сая төгрөгөөр хянаж, 201.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 109.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 559.4 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 15.4 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 559.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 15.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 574.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 559.4 сая, орон нутгийн төсвөөс 15.4 сая нийтдээ 574.8 сая төгрөгийн санхүүжилт авч, 1.7 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 484.1 сая төгрөг буюу 84.0 хувьтай буюу дансанд 92.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийг дэмжих	1323.5	1325.5	0	100%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	58419.9	56865.5	1554.4	97.3%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2757.3	2757.3	0	100%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1323.5	1310.0	13.5	99%
5	Боловсролын стандарт, сургалтын	288271.8	229222.9	59048.9	79.5%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	209012.7	177215.0	31797.7	84.8%

## Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

7	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	15447.9	15447.9	0	100%
	<b>Нийт дүн</b>	<b>576556.8</b>	<b>484142.1</b>	<b>92414.6</b>	<b>84.0%</b>

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 92.4 сая төгрөгийн бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 90.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 0.6 сая, нормативт зардал 1.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна. Шүүхийн шийдвэрээр нэг ажилтнаас 4.6 сая төгрөгийн төлбөрийг дансанд оруулсныг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэж, орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгт 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 74.8 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн.

## Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 316.0 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 71.8 сая төгрөгийн 26 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай гарсан зөрчилд холбоотой албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	71816.4	1	71816.4	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>71816.4</b>	<b>1</b>	<b>71816.4</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 18.2 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс	Зөвлөмж
-------------------	------------	--------------------------	--------	---------

**Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит**

			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан				Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	18,200.0					1	18,200.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>18200.0</b>					<b>1</b>	<b>18200.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								